

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны ... дугаар сарын ... өдөр

Дугаар ....

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл,  
зээлийн үйл ажиллагаанд баримтлах  
шаардлагыг тогтоох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан Монгол Улсын хууль, журмыг хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээлийн үйл ажиллагаанд мөрдсүгэй.
3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЛХАГВАСҮРЭН

Д.БАЯРСАЙХАН

Монголбанкны Ерөнхийлөгч,  
Санхүүгийн зохицуулах хорооны даргын  
2023 оны ... дугаар сарын ...-ний өдрийн  
... дугаар тушаалын Хавсралт

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас  
олгох зээлд баримтлах шаардлага

1. Зээл нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилготой байх;
2. Зээл хүсэгч нь Монгол Улсад бүртгэлтэй, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээд байх;
3. Төсөл, хөтөлбөр нь эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай, зээлийг эргэн төлөх чадвартай байх;
4. Төсөл, хөтөлбөрийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн байх;
5. Төслийн санхүүжилтийн дүн нь 100.0 тэрбум төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютын дүнгээс дээш байх;
6. Төсөл, хөтөлбөрийн эрсдэлийн үнэлгээ, санхүүжилт авах үндэслэл, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр нөлөөг мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх;
7. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад шаардлага.